

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/091/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> <a href="#">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarts@audit.gov.mn">otgonbayarts@audit.gov.mn</a> Аудитор: Ж.Баясгалан Утас: 7036-3047 Цахим хаяг: <a href="mailto:bayasgalanj@audit.gov.mn">bayasgalanj@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № САА-2026/091/НА-САА-ТМБ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА Д.ОКТЯБРЬ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газар нь Төрийн худалдан авах ажиллагааны газраас “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах гэрээ” байгуулан үнэ төлбөргүй ашиглахаар 75 инчийн 2,495.0 мянган төгрөгийн өнгөт телевизор шилжүүлж авсан, аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай 49 дүгээр тогтоолоор ХААГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 736.3 мянган төгрөгийн өртөгтэй тавилга, эд хогшлыг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сангийн яамнаас зарлагын гүйлгээ хийх эрхийг нээж өгөөгүйгээс шалтгаалж тайлант онд албан томилолтын зардлын 3,170.0 мянган төгрөг, урсгал засварын зардлын 87.5 мянган төгрөг болон ХХОАТ-ын 48.0 мянган төгрөг, нийт 3,305.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.5 хувиар дүгнэгдсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>38,995,700.00</b>	<b>7,374,100.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5</b>	<b>9,666,000.00</b>	<b>3,305,500.00</b>
33300	Татаас, санхүүжилтийн авлага		9,666,000.00	3,305,500.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>		<b>23,770,000.00</b>	0.00
34600	Урьдчилж гарсан зардал		23,770,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>5,559,700.00</b>	<b>4,068,600.00</b>
35400	Хангамжийн материал		5,559,700.00	4,068,600.00
35410	Бичиг хэргийн материал		1,287,200.00	220,000.00
35420	Аж ахуйн материал		3,432,500.00	3,648,600.00
35440	Түлш, шатах тослох материал		840,000.00	200,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>71,514,553.24</b>	<b>60,727,500.98</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>71,514,553.24</b>	<b>60,727,500.98</b>
39200	Биет хөрөнгө		70,345,803.27	59,696,251.03
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		45,549,430.19	47,805,368.00
39206	Хуримтлагдсан элэгдэл		(5,775,014.10)	(14,221,742.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		32,854,475.56	31,156,134.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(2,283,088.38)	(5,043,508.67)
39300	Биет бус хөрөнгө		1,168,749.97	1,031,249.95
39301	Програм хангамж		1,375,000.00	1,375,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(206,250.03)	(343,750.05)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>110,510,253.24</b>	<b>68,101,600.98</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>9,666,000.00</b>	<b>3,305,500.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>9,666,000.00</b>	<b>3,305,500.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>9</b>	<b>9,666,000.00</b>	<b>3,305,500.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		0.00	48,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		0.00	3,257,500.00
41360	Бусад өглөг		9,666,000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		9,666,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>100,844,253.24</b>	<b>64,796,100.98</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		<b>100,844,253.24</b>	<b>64,796,100.98</b>
51200	Хуримтлагдсан үр дүн		100,844,253.24	64,796,100.98
51210	Өмнөх үеийн үр дүн		0.00	100,844,253.24
51220	Тайлант үеийн үр дүн		100,844,253.24	(36,048,152.26)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>110,510,253.24</b>	<b>68,101,600.98</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тод-руулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2</b>	<b>371,257,450.81</b>	<b>373,129,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>39,879,293.14</b>	<b>373,129,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>39,879,293.14</b>	<b>2,765,500.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>		<b>2,000,000.00</b>	0.00

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,000,000.00	0.00
120009	Бусад орлого		0.00	87,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		36,879,293.14	2,498,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		1,000,000.00	180,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>		0.00	<b>370,364,100.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>		0.00	<b>370,364,100.00</b>
<b>12211</b>	<b>Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого</b>		0.00	<b>358,254,100.00</b>
122111	Урсгал санхүүжилтийн орлого		0.00	358,254,100.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		0.00	<b>12,110,000.00</b>
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0.00	12,110,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>331,378,157.67</b>	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>10,740,000.00</b>	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		10,740,000.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		<b>320,638,157.67</b>	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		320,638,157.67	0.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>270,413,197.57</b>	<b>402,983,576.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>270,413,197.57</b>	<b>402,983,576.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>240,518,538.57</b>	<b>364,854,838.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>178,235,123.42</b>	<b>263,269,707.39</b>
210101	Үндсэн цалин		94,259,232.85	137,958,873.46
210102	Нэмэгдэл		58,117,513.42	99,232,164.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6,091,353.15	18,240,000.00
210104	Урамшуулал		11,347,600.00	7,838,669.02
210105	Гэрээт ажлын хөлс		8,419,424.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>22,350,646.03</b>	<b>32,799,454.89</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал		15,294,665.51	22,303,629.33
210202	Тэтгэмжийн даатгалын зардал		1,754,507.85	2,623,956.38
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал		861,893.91	1,311,978.20
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал		857,681.91	1,311,978.20
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал		3,581,896.85	5,247,912.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>11,823,413.22</b>	<b>13,757,900.00</b>
210401	Бичиг хэрэг		4,107,150.00	3,163,700.00
210402	Тээвэр, шатахуун		6,360,000.00	7,320,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,356,263.22	1,738,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		0.00	875,700.00
210408	Бараа материал акталсны зардал		0.00	660,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		0.00	<b>20,636,900.00</b>

210604	Урсгал засвар		0.00	20,636,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		<b>16,042,000.00</b>	<b>11,300,000.00</b>
210702	Дотоод албан томилолт		16,042,000.00	11,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>6,267,816.00</b>	<b>8,020,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,222,816.00	7,547,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		45,000.00	473,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>5,799,539.90</b>	<b>15,070,876.62</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		-	680,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		5,799,539.90	14,390,876.62
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>29,894,659.00</b>	<b>38,128,737.72</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		<b>0.00</b>	<b>32,128,737.72</b>
<b>21311</b>	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>		<b>0.00</b>	<b>32,128,737.72</b>
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		0.00	32,128,737.72
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		0.00	32,128,737.72
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>29,894,659.00</b>	<b>6,000,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		18,954,659.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		10,940,000.00	6,000,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>100,844,253.24</b>	<b>(29,853,976.62)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>0.00</b>	<b>6,194,175.64</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз		0.00	6,194,175.64
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>		<b>0.00</b>	<b>(6,194,175.64)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>100,844,253.24</b>	<b>(36,048,152.26)</b>
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>371,257,450.81</b>	<b>373,129,600.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>333,378,157.67</b>	<b>380,030,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,000,000.00</b>	<b>380,030,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,000,000.00</b>	<b>12,110,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,000,000.00	12,110,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	12,110,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>0.00</b>	<b>367,920,100.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>0.00</b>	<b>367,920,100.00</b>

12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	358,254,100.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.00	358,254,100.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	9,666,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	9,666,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>331,378,157.67</b>	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,740,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,740,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,638,157.67	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,638,157.67	0.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>292,943,357.67</b>	<b>372,730,100.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,943,357.67</b>	<b>372,730,100.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>263,048,698.67</b>	<b>324,935,362.28</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>178,235,123.42</b>	<b>263,269,707.39</b>
210101	Үндсэн цалин	102,678,656.85	130,987,329.15
210102	Нэмэгдэл	58,117,513.42	106,203,709.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,091,353.15	18,240,000.00
210104	Урамшуулал	11,347,600.00	7,838,669.02
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,350,646.03</b>	<b>32,799,454.89</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	15,294,665.51	22,303,629.33
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	1,754,507.85	2,623,956.38
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	861,893.91	1,311,978.20
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	857,681.91	1,311,978.20
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	3,581,896.85	5,247,912.78
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,350,613.22</b>	<b>12,086,800.00</b>
210401	Бичиг хэрэг	5,394,350.00	2,096,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	6,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,263.22	1,738,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,600,000.00	1,751,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,922,500.00</b>	<b>2,659,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	-
210604	Урсгал засвар	17,922,500.00	2,659,400.00
2107	<b>Томилот, зочны зардал</b>	<b>16,042,000.00</b>	<b>11,300,000.00</b>
210702	Дотоод албан томилот	16,042,000.00	11,300,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,147,816.00</b>	<b>2,140,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,102,816.00	1,667,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,000.00	473,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>680,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	680,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,894,659.00</b>	<b>47,794,737.72</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>32,128,737.72</b>
21311	<b>Засгийн газрын дотоод шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>32,128,737.72</b>
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	32,128,737.72

2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	32,128,737.72
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,228,659.00</b>	<b>15,666,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,954,659.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,274,000.00	15,666,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>9,666,000.00</b>	<b>0.00</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,666,000.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>40,434,800.00</b>	<b>7,300,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>40,434,800.00</b>	<b>7,300,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,434,800.00</b>	<b>7,300,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>40,434,800.00</b>	<b>7,300,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,434,800.00	7,300,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(40,434,800.00)</b>	<b>(7,300,000.00)</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээ-ний нэмэг-дэл	Хуримтлагдсан үр дүн	Хяналтын бус хувь оролцоо	Нийт дүн
Тайлант үеийн үр дүн	100,844,253.24	0.00	100,844,253.24	0.00	100,844,253.24
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>
<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>	<b>0.00</b>	<b>100,844,253.24</b>
Тайлант үеийн үр дүн	(36,048,152.26)	0.00	(36,048,152.26)	0.00	(36,048,152.26)
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>64,796,100.98</b>	<b>0.00</b>	<b>64,796,100.98</b>	<b>0.00</b>	<b>64,796,100.98</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>370,364,100.00</b>	<b>338,235,362.28</b>	<b>32,128,737.72</b>	<b>91.33</b>
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>370,364,100.00</b>	<b>338,235,362.28</b>	<b>32,128,737.72</b>	<b>91.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>11,000,000.00</b>	<b>12,110,000.00</b>	<b>(1,110,000.00)</b>	<b>110.09</b>

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	11,000,000.00	12,110,000.00	(1,110,000.00)	110.09
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>359,364,100.00</b>	<b>326,125,362.28</b>	<b>33,238,737.72</b>	<b>90.75</b>
122005	Төсвөөс санхүүжих	359,364,100.00	326,125,362.28	33,238,737.72	90.75
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>370,364,100.00</b>	<b>338,235,362.28</b>	<b>32,128,737.72</b>	<b>91.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>370,364,100.00</b>	<b>338,235,362.28</b>	<b>32,128,737.72</b>	<b>91.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>363,364,100.00</b>	<b>332,235,362.28</b>	<b>31,128,737.72</b>	<b>91.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>264,463,900.00</b>	<b>263,269,707.39</b>	<b>1,194,192.61</b>	<b>99.55</b>
210101	Үндсэн цалин	131,088,000.00	130,987,329.15	100,670.85	99.92
210102	Нэмэгдэл	106,279,500.00	106,203,709.22	75,790.78	99.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,257,600.00	18,240,000.00	1,017,600.00	94.72
210104	Урамшуулал	7,838,800.00	7,838,669.02	130.98	100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,058,100.00</b>	<b>32,799,454.89</b>	<b>258,645.11</b>	<b>99.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,479,600.00	22,303,629.33	175,970.67	99.22
210202	Тэтгэмжийн даатгал	2,644,600.00	2,623,956.38	20,643.62	99.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,322,300.00	1,311,978.20	10,321.80	99.22
210204	Ажилгүйдлийн даатгал	1,322,300.00	1,311,978.20	10,321.80	99.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,289,300.00	5,247,912.78	41,387.22	99.22
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,868,500.00</b>	<b>12,086,800.00</b>	<b>6,781,700.00</b>	<b>64.06</b>
210401	Бичиг хэрэг	4,200,000.00	2,096,500.00	2,103,500.00	49.92
210402	Тээвэр, шатахуун	7,800,000.00	6,500,000.00	1,300,000.00	83.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,871,400.00	1,738,500.00	1,132,900.00	60.55
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,997,100.00	1,751,800.00	2,245,300.00	43.83
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,900,000.00</b>	<b>9,959,400.00</b>	<b>7,940,600.00</b>	<b>55.64</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,100,000.00	7,300,000.00	7,800,000.00	48.34
210604	Урсгал засвар	2,800,000.00	2,659,400.00	140,600.00	94.98
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,807,000.00</b>	<b>11,300,000.00</b>	<b>3,507,000.00</b>	<b>76.32</b>
210702	Дотоод албан томилолт	14,807,000.00	11,300,000.00	3,507,000.00	76.32
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,066,600.00</b>	<b>2,140,000.00</b>	<b>9,926,600.00</b>	<b>17.73</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,400,000.00	1,667,000.00	6,733,000.00	19.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	315,000.00	0.00	315,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	630,000.00	0.00	630,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,000.00	0.00	270,000.00	0.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	0.00	39,600.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,412,000.00	473,000.00	1,939,000.00	19.61
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,200,000.00</b>	<b>680,000.00</b>	<b>1,520,000.00</b>	<b>30.91</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,200,000.00	680,000.00	1,520,000.00	30.91
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,000,000.00</b>	<b>6,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>85.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,000,000.00</b>	<b>6,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>	<b>85.71</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,000,000.00	6,000,000.00	1,000,000.00	85.71
<b>8</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>9</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>7</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>14.00</b>	<b>14.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>7.00</b>	<b>7.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00	0.00	100.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1.00	1.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>9,666,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,666,000.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>9,666,000.00</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>9,666,000.00</b>
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,666,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,666,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,666,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,666,000.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,666,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,666,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,666,000.00

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана” гэж заасны дагуу ХААГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баясгалан гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ц.Отгонбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх нар тус тус хэрэгжүүлсэн.

ХААГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 270,413.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,704.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах төсвийг хэмнэж ажилласан байна. Үүнд:

- Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,
- Баяр ёслолтой холбоотой гардаг зардлуудыг зогсоосон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ХААГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс дараах 10 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт 2,10 сар
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 2,10 сар
- Байгууллагын батлагдсан төсөв 1 сар
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 сар
- Худалдан авах ажиллагааны тайлан 12 сар
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1,2 сар
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 7 сар

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.6, 6.4.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 431 дүгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлээгүй зарцуулж авлага үүсгэсэн, үндсэн үйл ажиллагааны орлогыг хууль журмын дагуу төлөвлөж, зарцуулаагүй, батлагдсан орон тоонд заагдаагүй ажилтан нэмж ажиллуулсан, сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт 41,865.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	6	41,865.6	6	41,865.6	100
Зөвлөмж	1	-	0	-	0.
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>41,865.6</b>	<b>6</b>	<b>41,865.6</b>	<b>85.7</b>

Өмнөх онд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож, мэдээлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн боловч биелүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,690.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 600.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 13,090.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

*Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 600.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,104.1 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.*

#### 5.1 Төлбөрийн акт

Албан хаагчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс 600.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:” 6.3.1 дэх “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1 дэх “Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, **тэтгэмж**, тэдгээртэй адилтгах бусад орлого” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгах төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Зөвлөмж

##### 1. Урамшуулалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үндэслэн, үр дүнг үнэлэлгүйгээр улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 13,090.4 мянган төгрөгийг тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.3 “Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана”, 2.4 “Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална”, УСНББОУС-39 “Ажилтны тэтгэмж”-ийн 5 (а)<sup>1</sup> гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг журамд заасан нөхцөл, шалгуурыг үндэслэн үнэлж, улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тооцож олгож байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Ажилтны тэтгэмжид дараах зүйлс хамаарна: Ажилтан нь холбогдох үйлчилгээгээ үзүүлсэн тайлант жилийн эцсээс хойш арван хоёр сарын дотор бүхэлдээ төлөгдөж барагдахаар хүлээгдэж буй доор дурдсан гэх мэт ажилтны богино хугацааны тэтгэмж, “Цалин, хөлс, нийгмийн даатгалын шимтгэл”, Тодруулга 55-д “Байгууллага нь тогтоосон шимтгэлийн хөтөлбөрийн хувьд зардал гэж хүлээн зөвшөөрсөн дүнг тодруулна”

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн.		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан хаагчдад олгосон түлээ, нүүрсний хөнгөлөлтөөс ХХОАТ суутгаагүй	1	600.0	1	600.0								
Үр дүнгийн мөнгөн урамшууллыг журамд заасны дагуу үнэлэлгүйгээр, тооцож олгосон.	1	13,090.4					1	13,090.4				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>13,690.4</b>	<b>1</b>	<b>600.0</b>			<b>1</b>	<b>13,090.4</b>				

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>				<b>1</b>			